

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 12 дугаар Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/214/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ний партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: П.Мөнхцэцэг
Утас: 88509135 Цахим хаяг: munkh_9135@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/160
танай _____-ны № _____-т

МӨРӨН СУМЫН 12 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ С.ГҮНДСАМБА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 418,974.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 56,536.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 80,047.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Бусад асуудлын хэсэг

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангалтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг харившлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,528,504.40</u>	<u>109,045,647.57</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	56,536,299.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	56,536,299.47
3121	Төгрөг	00.00	56,536,299.47
31211	Төрийн сангийн харилцах	00.00	56,536,299.47
35	БАРАА МАТЕРИАЛ	37,528,504.40	52,509,348.10
354	Хангамжийн материал	37,528,504.40	52,509,348.10
35410	Бичиг хэргийн материал	00.00	185,000.00
35420	Аж ахуйн материал	345,600.00	1,263,000.00
35460	Хүнсний материал	5,194,912.40	11,354,726.10
35470	Бусад хангамжийн материал	31,987,992.00	39,706,622.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>925,681,465.19</u>	<u>911,568,662.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	925,681,465.19	911,568,662.38
392	Биет хөрөнгө	906,210,965.19	891,267,862.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	885,704,640.16	885,704,640.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,100,272.80	-69,467,030.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,346,802.00	66,783,497.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,698,401.26	-18,159,831.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,489,017.35	42,489,017.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,423,037.54	-19,671,939.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,935,229.58	4,935,229.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,207,612.30	-1,510,320.58
39217	Ном	164,600.00	164,600.00
393	Биет бус хөрөнгө	19,470,500.00	20,300,800.00
39301	Програм хангамж	313,500.00	313,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-62,700.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,157,000.00	20,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>963,209,969.59</u>	<u>1,020,614,309.95</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>963,209,969.59</u>	<u>1,020,614,309.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	963,209,969.59	1,020,614,309.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,157,000.00	20,050,000.00
51101	Өмч: - төрийн	19,157,000.00	20,050,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	776,476,038.59	832,987,378.95
51210	Өмнөх үеийн үр дүн	776,476,038.59	776,476,038.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	56,511,340.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,576,931.00	167,576,931.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>963,209,969.59</u>	<u>1,020,614,309.95</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	440,901,049.35	538,080,427.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,184,583.35	39,059,127.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,184,583.35	39,059,127.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,184,583.35	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,184,583.35	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	55,479,266.00	499,021,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	418,974,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	418,974,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,237,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,261,166.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,368,166.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	893,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,218,100.00	80,047,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,218,100.00	80,047,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	426,966,236.38	481,569,086.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,966,236.38	481,569,086.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,800,412.22	481,569,081.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,591,721.27	293,012,036.42
210101	Үндсэн цалин	216,429,942.87	222,751,421.04
210102	Нэмэгдэл	23,488,628.90	55,114,381.97
210104	Урамшуулал	26,673,149.50	15,146,233.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,313,545.56	37,178,164.81
210201	Тэтгэврийн даатгал	24,040,892.00	25,951,765.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,655,571.26	2,878,154.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,124,581.00	2,285,723.32
210204	Ажилгүйдлийн даатгал	499,345.62	551,138.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,993,155.68	5,511,383.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,046,752.20	48,942,694.61
210301	Гэрэл, цахилгаан	1,902,516.00	3,533,893.11
210302	Түлш, халаалт	39,548,457.20	40,442,700.00
210303	Цэвэр, бохир ус	3,595,779.00	4,966,101.50
2104	Хангамж, бараа материалын зардал	9,446,206.00	17,516,720.00
210401	Бичиг хэрэг	1,420,800.00	3,713,400.00
210402	Тээвэр, шатахуун	242,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,500.00	253,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,402,166.00	95,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,244,740.00	11,105,820.00

210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,349,000.00
2105	Нормативт зардал	9,463,904.30	37,284,465.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,770.00	99,879.30
210502	Хоол, хүнс	9,281,134.30	37,184,586.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,772,700.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	7,772,700.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	96,000.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,331,200.00	1,675,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	791,200.00	861,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,738,382.89	38,879,499.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	623,000.00	2,198,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,348,600.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,766,782.89	33,681,499.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,165,824.16	05.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	398,647.80	05.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	398,647.80	05.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,767,176.36	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,767,176.36	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>13,934,812.97</u>	<u>56,511,340.36</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>13,934,812.97</u>	<u>56,511,340.36</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>432,716,466.00</u>	<u>499,021,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>432,716,466.00</u>	<u>499,021,300.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	418,974,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	418,974,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,237,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,261,166.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,368,166.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	893,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,218,100.00	80,047,000.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,218,100.00	80,047,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	399,316,466.00	442,485,000.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,316,466.00	442,485,000.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,150,641.84	442,484,995.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,591,721.27	293,012,036.42
210101	Үндсэн цалин	216,429,942.87	222,751,420.04
210102	Нэмэгдэл	23,488,628.90	55,114,381.97
210104	Урамшуулал	26,673,149.50	15,146,234.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,774,208.47	37,178,164.81
210201	Тэтгэврийн даатгал	24,501,554.91	25,951,765.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,655,571.26	2,878,154.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,124,581.00	2,285,723.32
210204	Ажилгүйдлийн даатгал	499,345.62	551,138.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,993,155.68	5,511,383.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,046,752.20	48,942,694.61
210301	Гэрэл, цахилгаан	1,902,516.00	3,533,893.11
210302	Түлш, халаалт	39,548,457.20	40,442,700.00
210303	Цэвэр, бохир ус	3,595,779.00	4,966,101.50
2104	Хангамж, бараа материалын зардал	7,168,666.00	00.00
210401	Бичиг хэрэг	533,400.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	242,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,500.00	00.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,442,166.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,614,600.00	00.00
2105	Нормативт зардал	11,289,793.90	43,344,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,800.00	00.00
210502	Хоол, хүнс	10,489,993.90	43,344,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	727,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,772,700.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	7,772,700.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	96,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,331,200.00	814,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	791,200.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,079,600.00	12,193,699.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,168,000.00	9,193,699.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,911,600.00	3,000,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,165,824.16	05.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	398,647.80	05.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	398,647.80	05.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,767,176.36	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,767,176.36	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,400,000.00</u>	<u>56,536,299.47</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,400,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,400,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,400,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,400,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-33,400,000.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	56,536,299.47
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	56,536,299.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	802,564,563.72	802,564,563.72
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,279,487.50	-17,279,487.50
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,157,000.00	167,576,931.00	776,476,038.59	963,209,969.59
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	893,000.00	00.00	00.00	893,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	56,511,340.36	56,511,340.36
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,050,000.00	167,576,931.00	832,987,378.95	1,020,614,309.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	499,021,300.00	442,484,995.14	56,536,304.86	88.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	499,021,300.00	442,484,995.14	56,536,304.86	88.7
210	Бараа, үйлчилгээний зардал	499,021,300.00	442,484,995.14	56,536,304.86	88.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,171,600.00	293,012,036.42	44,159,563.58	86.9
210101	Үндсэн цалин	266,356,800.00	222,751,420.04	43,605,379.96	83.6
210102	Нэмэгдэл	65,470,600.00	55,114,381.97	10,356,218.03	84.2
210104	Урамшуулал	5,344,200.00	15,146,234.41	(9,802,034.41)	283.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,690,700.00	37,178,164.81	4,512,535.19	89.2
210201	Тэтгэврийн даатгал	28,502,900.00	25,951,765.18	2,551,134.82	91.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,297,300.00	2,878,154.07	419,145.93	87.3
210203	ҮОМШӨ ний даатгал	2,637,300.00	2,285,723.32	351,576.68	86.7
210204	Ажилгүйдлийн даатгал	659,200.00	551,138.40	108,061.60	83.6
210205	Эрүүл мэндийн даатгал	6,594,000.00	5,511,383.84	1,082,616.16	83.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,942,700.00	48,942,694.61	5.39	100.0
210301	Гэрэл цахилгаан	3,500,000.00	3,533,893.11	(33,893.11)	101.0
210302	Түлш, халаалт	40,243,700.00	40,442,700.00	(199,000.00)	100.5
210303	Цэвэр, бохир ус	5,199,000.00	4,966,101.50	232,898.50	95.5
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	-
210401	Бичиг хэрэг	-	-	-	-
210402	Тээвэр (шатахуун)	-	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	-	-	-
2105	Нормативт зардал	51,206,600.00	43,344,400.00	7,862,200.00	84.6
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	51,206,600.00	43,344,400.00	7,862,200.00	84.6
210503	Нормын хувцас зөөлөн	-	-	-	-

	эдлэл				
2106	Эд хогшил худалдан авах	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	814,000.00	814,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	-	-
210806	Мэдээллийн технологийн зардал	814,000.00	814,000.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	12,195,700.00	12,193,699.30	2,000.70	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,195,700.00	9,193,699.30	2,000.70	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	499,021,300.00	499,021,294.61	5.39	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,974,300.00	418,974,300.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	418,974,300.00	418,974,300.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,047,000.00	80,046,994.61	5.39	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	80,047,000.00	80,046,994.61	5.39	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	56,536,299.47	(56,536,299.47)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	190.00	110.00	80.00	57.9
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	190.00	110.00	80.00	57.9
630001	Төрийн өмчит ЕБС	190.00	110.00	80.00	57.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд "Хүүхэд бүрийн эрүүл аюулгүй хөгжих үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах" гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал үндэслэн, дадал, чадварын түвшинг тогтоож хоцрогдсон агуулгыг нөхөх
2. Хүүхдийн хоол хүнсний хадгалалт нийлүүлэлт, чанар хүртээмжид ахиц гаргаж, технологи картыг баяжуулан мөрдөх
3. Дижитал технологийг хичээл, сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх
4. Хүүхэд багш ажилтны эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг хөгжүүлэх

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Мөрөн сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг хангалттай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж,

хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.

- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 05 сарын 01 өдрийн А/11 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан ажилласан байна. Дотоод хяналтыг голчлон хүүхдийн хоолны чанар, норм, ариун цэвэр орчныг сайжруулах, хүүхдийн сурч боловсрох орчныг сайруулах, багийн ажлын үнэлгээ гэх мэт асуудалд анхаарч хэрэгжүүлсэн байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,404.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	56,536.30	(56,536.30)
Авлага	-	-	-
Бараа материал	37,528.50	52,509.35	(14,980.84)
Үндсэн хөрөнгө	925,681.47	911,568.66	14,112.80
Нийт хөрөнгө	963,209.97	1,020,614.31	(57,404.34)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	963,209.97	1,020,614.31	(57,404.34)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	963,209.97	1,020,614.31	(57,404.34)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Гол нөлөө үзүүлсэн данстыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 56,536.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 418,974.3 мянган, орон нутгийн төсвөөс, 80,047.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 131,403.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 418,974.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 80,047.0 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс авах дүнг их хэмжээгээр нэмэгдүүлсэн нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, нөгөө талаас боловсролын салбарын төсвийн шинэчлэлтээс шалтгаалсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/392 тоот тушаалаар төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулсан байна. Анх батлагдсан төсвийг тодотгож, 133,403.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийг Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор болон аймгийн засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/429 тоот захирамжаар 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 28,807.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувь хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 418,974.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 80,047.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 418,974.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 56,536.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 80,047.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 5.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 442,484.9 мянган төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 56,536.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 80111	55,942.7	55,942.6	0.1	100
2	Нийтлэг үйлчилгээ 80112	24,104.3	24,104.3		100
3	Эрүүл мэндийг дэмжих 81605	1,100.0	1,100.0		100
4	Хоол хүнс 81807	51,206.6	43,344.5	7,862.1	84.6
5	Хүүхдэд ээлтэй орчин 81816	1,715.0	1,715.0		100
6	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх зардал 81823	1,100.0	1,098.0		100
7	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 81834	288,506.6	257,680.7	30,825.9	89.3
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 81835	75,345.4	57,499.1	17,846.3	76.3
9	Нийт дүн	499,021.3	442,484.9	56,536.8	97.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар орлого, зардал гараагүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нэмэлтээр орлого хүлээн авч зарцуулаагүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Нью-баланс аудит ХХК-ний ахлах аудитор П.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг Нью-баланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 426,966.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,539.3 мянган төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн материаллаг байдлыг 6,831.5 мянган төгрөгөөр тооцсоныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тус байгууллагад дэд болон орлогч даргын орон тоо бүтэц, орон тоонд нь батлагдаагүй, албан тушаалын автомашин байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл зэргийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн 5 сая төгрөгөөс дээш зарлагын 32,859.2 мянган төгрөгийн 6 гүйлгээ, орлогын 20,640.4 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 зөвлөмжийг хүргүүлсэн ба биелэлт 100 хувь байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2		2		
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгө данс 56,536.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба хянаж үзэхэд цалингийн санд 44,159.6 мянган төгрөг, хоолны зардалд 7,862.2 мянган төгрөг байна. Үүний зарцуулалтыг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,499.6 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 5.4 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд цэвэрлэж залруулсан болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Цалингийн 5 сая төгрөгөөс дээш зарлагын 32,859.2 мянган төгрөгийн 6 гүйлгээ, орлогын 20,640.4 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дэх заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төвлөрүүлсэн гүйлгээг цэвэрлэж бичилт хийгээгүй	1	5.4	0	0	1	5.4	1	5.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл	10	53,499.6					1	53,499.6				0

АУДИТЫН ТАЙЛАНГ:


ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Л.МАНДАХНАРАН ОГНОО:

БЭЛТГЭСЭН:

НЬЮ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Handwritten signature

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: 2023.08.17